



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БӨА-2022/155/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: Kalim_riza@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|-----------|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 10 |
| 3. Аудитын тайлан..... | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 11 |
| 3.4 Материаллаг байдал | 12 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 14 |
| 3.8 Аудитын гол асуудал | 14 |



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgi@audit.gov.mn

ӨЛГИЙ СУМЫН ХОТГОР БАГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Ж.ТАНШОЛПАН ТАНАА

2022.08.25 № 207
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өлгий сумын Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--|----------------------------|----------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>10815709.12</u> | <u>12751477.00</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 0.00 | 0.00 |
| 33 | АВЛАГА | 2025000.00 | 0.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2025000.00 | 0.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 8790709.12 | 12751477.00 |
| 351 | Түүхий эд материал | 6276234.00 | 10408901.09 |
| 35130 | Эм боох материал | 6276234.00 | 10408901.09 |
| 354 | Хангамжийн материал | 2514475.12 | 2342575.91 |
| 35420 | Аж ахуйн материал | 499850.00 | 601850.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 400500.00 | 217372.99 |
| 35460 | Хүнсний материал | 1614125.12 | 1523352.92 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>296863483.00</u> | <u>300969877.55</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 296863483.00 | 300969877.55 |
| 392 | Биет хөрөнгө | 293909482.84 | 298169877.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2146400.00 | 2146400.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -626429.94 | -908117.22 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 31790000.00 | 31790000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -529833.33 | -6887833.29 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 20363265.03 | 37843863.34 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -7564805.06 | -13519587.74 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14152285.50 | 14152285.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -10821399.36 | -11447133.24 |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 245000000.00 | 245000000.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 2954000.16 | 2800000.20 |
| 39301 | Програм хангамж | 770000.00 | 770000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -615999.84 | -769999.80 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 2800000.00 | 2800000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>307679192.12</u> | <u>313721354.55</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>0.00</u> | <u>926800.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 0.00 | 926800.00 |
| 4136 | Бусад өглөг | 0.00 | 926800.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 926800.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>307679192.12</u> | <u>312794554.55</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 307679192.12 | 312794554.55 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал | 51333200.00 | 51333200.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 51333200.00 | 51333200.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 255303903.96 | 260419266.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 255303903.96 | 255303903.96 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 5115362.43 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1042088.16 | 1042088.16 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>307679192.12</u> | <u>313721354.55</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 246,720,896.00 | 248,620,157.97 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,356,600.00 | 9,131,828.66 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 245,364,296.00 | 239,488,329.31 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 199,766,100.00 | 219,236,298.31 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 16,460,598.31 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 199,766,100.00 | 202,775,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 754,996.00 | 17,330,831.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 754,996.00 | 17,330,831.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 44,843,200.00 | 2,921,200.00 |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт | 41,790,000.00 | - |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | 3,053,200.00 | 2,921,200.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 200,872,684.03 | 243,504,795.54 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 200,872,684.03 | 243,504,795.54 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 185,892,984.03 | 226,704,795.54 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 142,705,000.00 | 159,851,200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 95,364,942.00 | 91,769,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 38,933,258.00 | 45,932,300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 3,024,000.00 |
| 210104 | Урамшуулал | 8,406,800.00 | 10,305,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 8,820,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19,538,600.00 | 24,090,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,749,400.00 | 17,552,800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,447,300.00 | 1,634,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,157,800.00 | 1,307,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 289,500.00 | 326,900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,894,600.00 | 3,269,000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2,005,500.00 | 2,019,527.01 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 705,400.00 | 205,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,300,100.00 | 1,814,127.01 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,995,800.00 | 8,774,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 208,100.00 | 614,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,135,000.00 | 6,435,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300,200.00 | 600,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 352,500.00 | 317,200.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 807,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 5,225,942.71 | 15,535,333.77 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,975,463.21 | 15,236,561.57 |
| 210502 | Хоол, хүнс | 415,479.50 | 156,272.20 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 835,000.00 | 142,500.00 |

| | | | |
|-------------|--|----------------------|---------------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 697,800.00 | 1,084,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 697,800.00 | 1,084,800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 385,200.00 | 908,831.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 385,200.00 | 908,831.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4,292,300.00 | 705,400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,956,900.00 | 300,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 233,700.00 | 300,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 18,000.00 | 18,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48,400.00 | 48,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19,000.00 | 19,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 16,300.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | 20,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,046,841.32 | 13,734,203.76 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,050,700.00 | 360,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,996,141.32 | 13,374,203.76 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 14,979,700.00 | 16,800,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 16,800,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 16,800,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 14,979,700.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 14,979,700.00 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 45,848,211.97 | 5,115,362.43 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 45,848,211.97 | 5,115,362.43 |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| D01 | 2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 51,333,200.00 | 1,042,088.16 | 255,303,903.96 | 307679192,12 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 51,333,200.00 | 1,042,088.16 | 255,303,903.96 | 307679192,12 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 5,197,652.86 | 5197652,86 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 51,333,200.00 | 1,042,088.16 | 260,501,556.82 | 312876844,98 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|----------------------------|----------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>203574296.00</u> | <u>223027731.00</u> |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 203574296.00 | 223027731.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 199766100.00 | 202775700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 199766100.00 | 202775700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 754996.00 | 17330831.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 754996.00 | 17330831.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 3053200.00 | 2921200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 3053200.00 | 2921200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>202121196.00</u> | <u>222007731.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 202121196.00 | 222007731.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 187141496.00 | 205207731.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 144730000.00 | 159851200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 98922800.00 | 91769500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37400400.00 | 45932300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 3024000.00 |
| 210104 | Урамшуулал | 8406800.00 | 10305400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 8820000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19538600.00 | 22065900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13749400.00 | 15527800.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1447300.00 | 1634600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1157800.00 | 1307600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 289500.00 | 326900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2894600.00 | 3269000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2355400.00 | 1723400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 705400.00 | 205400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1650000.00 | 1518000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7018400.00 | 7949800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 208100.00 | 614600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6135000.00 | 5508800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300200.00 | 600000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 375100.00 | 360000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 866400.00 |
| 2105 | Нормативт зардал | 7323096.00 | 10445400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 5254996.00 | 9437900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1153100.00 | 65500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 915000.00 | 942000.00 |

| | | | |
|-------------|--|--------------------|--------------------|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 697800.00 | 1197800.00 |
| 210604 | Урсгал засвар | 697800.00 | 1197800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 385200.00 | 908831.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 385200.00 | 908831.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 4292300.00 | 705400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3956900.00 | 300000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 233700.00 | 300000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 18000.00 | 18000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48400.00 | 48400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19000.00 | 19000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 16300.00 | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | 20000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 800700.00 | 360000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 800700.00 | 360000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 14979700.00 | 16800000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 16800000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 16800000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>1453100.00</u> | <u>1020000.00</u> |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 1453100.00 | 1020000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1453100.00 | 1020000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-1453100.00</u> | <u>-1020000.00</u> |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|--------------|-----------------------|--------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 202819300.00 | 187839600.00 | 205696900.00 | 205696900.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 202819300.00 | 187839600.00 | 205696900.00 | 205696900.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 202819300.00 | 187839600.00 | 205696900.00 | 205696900.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 144730000.00 | 144730000.00 | 159851200.00 | 159851200.00 |
| 210101 | Үндсэн цалин | 98922800.00 | 98922800.00 | 91769500.00 | 91769500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37400400.00 | 37400400.00 | 45932300.00 | 45932300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | 3024000.00 | 3024000.00 |
| 210104 | Урамшуулал | 8406800.00 | 8406800.00 | 10305400.00 | 10305400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | | 8820000.00 | 8820000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 19538600.00 | 19538600.00 | 22065900.00 | 22065900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13749400.00 | 13749400.00 | 15527800.00 | 15527800.00 |

| | | | | | |
|-------------|--|-------------|------------|-------------|-------------|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1447300.00 | 1447300.00 | 1634600.00 | 1634600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1157800.00 | 1157800.00 | 1307600.00 | 1307600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 289500.00 | 289500.00 | 326900.00 | 326900.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2894600.00 | 2894600.00 | 3269000.00 | 3269000.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 2355400.00 | 2355400.00 | 1723400.00 | 1723400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 705400.00 | 705400.00 | 205400.00 | 205400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1650000.00 | 1650000.00 | 1518000.00 | 1518000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 7146700.00 | 7018400.00 | 7949800.00 | 7949800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 336400.00 | 208100.00 | 614600.00 | 614600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6135000.00 | 6135000.00 | 5508800.00 | 5508800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 300200.00 | 300200.00 | 600000.00 | 600000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариугал | 375100.00 | 375100.00 | 360000.00 | 360000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | | 866400.00 | 866400.00 |
| 2105 | Нормативт зардал | 11153100.00 | 6653100.00 | 10445400.00 | 10445400.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8000000.00 | 4500000.00 | 9437900.00 | 9437900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 1153100.00 | 1153100.00 | 65500.00 | 65500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2000000.00 | 1000000.00 | 942000.00 | 942000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10510900.00 | 2065900.00 | 2217800.00 | 2217800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7313100.00 | 1368100.00 | 1020000.00 | 1020000.00 |
| 210602 | Тавилга | 2500000.00 | 0.00 | | |
| 210604 | Урсгал засвар | 697800.00 | 697800.00 | 1197800.00 | 1197800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 385200.00 | 385200.00 | 378000.00 | 378000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 385200.00 | 385200.00 | 378000.00 | 378000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 6198700.00 | 4292300.00 | 705400.00 | 705400.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5856900.00 | 3956900.00 | 300000.00 | 300000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 233700.00 | 233700.00 | 300000.00 | 300000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 18000.00 | 18000.00 | 18000.00 | 18000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 48400.00 | 48400.00 | 48400.00 | 48400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 19000.00 | 19000.00 | 19000.00 | 19000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 16300.00 | 16300.00 | | |
| 210807 | Газрын төлбөр | 6400.00 | | | |

| | | | | | |
|-------------|--|--------------|--------------|--------------|--------------|
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | | 20000.00 | 20000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 800700.00 | 800700.00 | 360000.00 | 360000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 800700.00 | 800700.00 | 360000.00 | 360000.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 202819300.00 | 187839600.00 | 205696900.00 | 205696900.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 199766100.00 | 184786400.00 | 202775700.00 | 202775700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 199766100.0 | 184786400.0 | 202775700.00 | 202775700.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 3053200.00 | 3053200.00 | 2921200.00 | 2921200.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 3053200.0 | 3053200.0 | | |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | | 2921200.00 | 2921200.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 0.00 | 0.00 | 15.00 | 15.00 |
| 620001 | Удирдах ажилтан | | | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | | | 7.00 | 7.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | | | 5.00 | 5.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | | | 2.00 | 2.00 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|------------|--|-----------|-------------|
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 754996.00 | 17330831.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 754996.00 | 17330831.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 754996.00 | 530831.00 |
| 2105 | Нормативт зардал | 754996.00 | 0.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 754996.00 | |
| 2107 | Томилолт, зочны зардал | 0.00 | 530831.00 |
| 210702 | Дотоод албан томиллолт | | 530831.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 0.00 | 16800000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 0.00 | 16800000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | 16800000.00 |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Өлгий сумын Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн эрхэм зорилго нь “ Ард иргэдэд таатай орчинд түргэн шуурхай үйлчилж аливаа эрсдлээс урьдчлан сэргийлэх, ажлын үр дүнг үнэлж тооцон, үр дүнд суурилсан хяналт, үнэлгээний систем нэвтрүүлэх, ажилтан нэг бүрийг хөгжүүлж, нээлттэй уян хатан үйлчилгээтэй “Бүтээлч, тэргүүний хамт олон” болох” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2 хувиар буюу 4.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6.0 сая төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|-----------------|-----------------|---------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 2025.0 | | (2025.0) |
| Бараа материал | 8790.7 | 12751.5 | 3960.8 |
| Үндсэн хөрөнгө | 296863.5 | 300969.9 | 4106.4 |
| Нийт хөрөнгө | 307679.2 | 313721.4 | 6042.2 |
| Өр төлбөр | | 926.8 | 926.8 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 307679.2 | 312794.5 | 5115.5 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 307679.2 | 313721.4 | 6042.2 |

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн татварт 2.0 сая төгрөгийн авлагатай байсан ба тайлант онд авлагаа бүрэн барагдуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 12.7 сая төгрөг болж оны эхнээс 4.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь эм боох материал 4.1 сая төгрөгөөр, бусад хангамжийн материалын үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр нэмэгдэж, түлшний үлдэгдэл 0.1 сая төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 10.7 сая төгрөгийн эм боох материал 3.1 сая төгрөгийн аж ахуйн материал, 1.4 сая төгрөгийн түлш, 6.4 сая төгрөгийн шатахуун, 0.1 сая төгрөгийн

хүнсний материал, 0.6 сая төгрөгийн бичиг хэргийн зүйл зэргээр нийтдээ 21.8 сая төгрөгийн бараа материалыг худалдан авсан ба 9.1 сая төгрөгийн эм боох материалыг үнэ төлбөргүйгээр хүлээж авч, нийтдээ 30.9 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч, 27.0 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зохих зарлагын баримтуудыг үндэслэн зарцуулсан байна.

Төсвийн хөрөнгөөр тайлант онд 1.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан ба 16.5 сая төгрөгийн Ковидын эмчилгээний тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг аймгийн ЭМГазраас үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө, үндсэн хөрөнгийн тайлант оны 13.4 сая төгрөгийн элэгдлийн зардлын дүнгийн зөрүүгээр оны эхнээс 4.1 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Цар тахалтай холбоотойгоор шатахууны зардал хэтэрч оны эцэст 0.9 сая төгрөгийн өр үүсчээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 248.0 сая төгрөг байгаа ба тайлант онд цар тахалтай холбоотой 16.5 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийгдсэн, үнэ төлбөргүй 9.1 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгдсэн мөн дээд шатны байгууллагаас эмч ажилчдын тэтгэмжинд 17.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон ба өнгөрсөн онд 45.6 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт хийгдсэний зөрүүгээр өмнөх оноос орлого 1.9 сая төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос нийт дүнгээр 42.6 сая төгрөгөөр өссөн нь урьд оноос цалин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 21.7 сая төгрөгөөр, эмийн зардал 11.2 сая төгрөгөөр өсөж, томилолтын зардал 0.6 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 1.8 сая төгрөгөөр өссөн болон бусад бараа үйлчилгээний зардлуудын өсөлт, бууралт нөлөөлжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны төсвийг Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор 205.7 сая төгрөгөөр баталжээ.

Нийт төсвийн 202.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 2.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ЭМГазраас цалингийн зардлыг 3.6 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 0.5 сая төгрөгөөр, өвчтөний хоолны зардлыг 0.7 сая төгрөгөөр тус тус бууруулж тодотгон эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслийн зардлыг 4.3 сая төгрөгөөр, урсгал засварын зардлыг 0.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн нийт төсвийн дүнд өөрчлөлт оруулаагүйгээр баталсан байна.

Дээрхи байдлаар зардал хооронд шилжүүлэх замаар төсвийн тодотгол хийсэн нь өвчний дэгдэлттэй холбоотой зарим зардлуудыг нэмэх зайлшгүй шаардлага гарсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 202.8 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 2.9 сая төгрөгийн, нийтдээ 205.7 сая төгрөгийн санхүүжилт авч батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 205.7 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 88.4 хувийг цалин, НДШ-ийн зардал, 0.8 хувийг тогтмол зардал, 3.9 хувийг хангамж бараа материалын зардал, 5.0 хувийг норматив зардал, 1.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар Аймгийн ЭМГазраас нэмэлт санхүүжилтээр 17.3 сая төгрөг олгогдсон ба Эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасны дагуу эмч, эрүүл мэндийн ажилтнуудын тэтгэмжинд 16.8 сая төгрөгийг, томилолтын зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

Хотгор багийн Эрүүл мэндийн төв нь “Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулинд заасан “хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, эрүүл мэндийн үйлчилгээ тэгш, хүртээмжтэй байх” зарчмын хүрээнд үйл ажиллагаа явуулж бэлэн байдлын горимоор ажилласан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Хотгор багийн Эрүүл мэндийн төвийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 118 мэдээллийг хугацаандаа оруулсан, 1 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр авлага үүссэн талаархи 2,0 сая төгрөгийн мэдээллийг, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй байна. Шилэн дансны мэдээллийн хэрэгжилтийн дундаж хувь 90% -тай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага үүсгэсэнтэй холбоотой албан шаардлага өгөгдөж биелэлтийг хугацаандаа ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт илэрсэн 18.8 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Акт тогтоогдоогүй

4.3 Албан шаардлага

Үгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тайлагналтай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ажилчдад олгосон тэтгэмжийн 16.8 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2,14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1 дэхь заалтуудыг мөрдөж, цаашид зардлын гүйлгээг өглөг дансаар дамжуулан тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах.

2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тайлант оны шилэн дансны мэдээллийг шалгахад 2,0 сая төгрөгийн авлага үүссэн мэдээллийг оруулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 90 хувьтай байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хотгор Хүн эмнэлэг | 2 | 18.8 | | | | | | | 2 | 18.8 |